

Б У Г Д Н А И Р А М Д А Х М О Н Г О Л А Р Д У Л С Ы Н Ш И Н Ж Л Э Х  
У Х А А Н, Д Э Э Д Б О Л О В С Р О Л Ы Н Х Ü Р Э Э Л Э Н Г И Й Н Х Э Л  
З О Х И О Л С У Д Л А Х Г А З Р Ы Н Ц Ü В Р А Л Б И Ч И Г  
Х Э Л З О Х И О Л

Тэргүүн боть

Гуравдугаар дэвтэр

МАУ  
СЭУА  
000415 1  
00742(6)

БАРАЙШИР (Улаанбаатар)

ҮСГИЙН ДҮРМИЙН  
ЗАРЧМЫН ТУХАЙ



У л а а н б а а т а р  
1959

# Х Э Л З О Х И О Л

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ШИНЖЛЭХ  
УХААН, ДЭЭД БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ХЭЛ  
ЗОХИОЛ СУДЛАХ ГАЗРЫН ЦУВРАЛ БИЧИГ

*Найруулан засагч эрдэм шинжилгээний  
ахлах ажилтан Лувсандэндэв, Ринченсамбуу*

## Үсгийн дүрмийн зарчмын тухай

Шинжлэх Ухаан, Дээд Боловсролын  
Хүрээлэнгийн Эрдэм Шинжилгээний  
хэвлэлийн газар

Улаанбаатар

1959

## ҮСГИЙН ДҮРМИЙН ЗАРЧМЫН ТУХАЙ

Үсгийн дүрмийн зарчмын тухай асуудал бол аливаа хэлний зөв бичих дүрмийг боловсруулан тогтооход нэн тэргүүн шаардагдах эрхэм чухал асуудлуудын нэг юм. Учир нь, ямар нэгэн тодорхой зарчмыг үндэс болгоогүй үсгийн дүрэм байхад бэрхтэй билээ.

Үсгийн дүрмийн сайн муу болох нь уг дүрмийн суурилан тулгуурлах зарчмын асуудлыг хир зэрэг зөв боловсруулснаас ихээхэн шалтгаална. Хэрэв үсгийн дүрмийн гол болговол зохих зарчмыг эс голлох буюу эсхүл нэрийн төдий баримталж ерөнхийлөн хавтгайруулбал, уул дүрмийн чанарыг сулруулж, элдэв будлиан самуурал гарахад хүргэнэ.

Хүний үг яриаг бичигт нэгэн янзаар буулган дамжуулах арга зүйн тогтолцоог үсгийн дүрэм буюу зөв бичих дүрэм гэдээг. Өөрөөр хэлбэл, аливаа хэлний үгсийг нийтээр нэгэн мөр болгон дагаж бичих журмыг үсгийн дүрэм гэнэ.

Үсэг бичиг хэрэглэсэн анхны үед жинхэнэ бичиж тэмдэглэсэн, нарийн тогтолцоотой үсгийн дүрэм байсангүй. Харин хожим бичгийн хөгжлийн явцад үсгийн дүрэм бий болжээ. Үсгийн дүрэм бол ард нийтийн үг яриаг бичгээр илэрхийлэх нийтлэг чанартай арга хэрэглүүр бөгөөд аливаа үг яриаг зурмаг буюу үсгийн дүрсээр дамжуулах ёс зүйг эмхлэн тохируулна. Үсгийн дүрмийг дотор нь их төлөв хоёрзүйл болгон хуваадаг үүнд: 1-д, үсгийн тэмдгийг хэрэглэх дүрэм, 2-т, цэг тэмдгийг хэрэглэх дүрэм гэж хоёр томхон хэсэг болгож хуваана.

15. 0015

Үсгийн дүрмийн онцлог нь тухайн хэлний үг бүрийн дуудлагын өвөрмөц байдлыг харгалзахгүй, харин нийт үгийг бичигт нэг янзаар тэмдэглэх журмыг тогтоож өгдөгт оршино. Үүгээрээ үсгийн дүрэм нь: 1-д, үг болгоныг яг тэр хэвээр нь буюу өвөрмөц хэлбэрээр нь бичигт оруулах явдлыг хязгаарлана. 2-т, үг бүрийн өвөрмөц дуудлагыг үл хайхран нийт бичлэгийг нэгэн мөр болгож өгнө. Энэ нь бичиг зохиолын зүйлийг хялбархан ойлгох боломжийг уншигчдад олгодог байна.

Хэрэв нийтээр дагаж мөрдөх үсгийн дүрэмгүй бол хүн бүр дур дураараа бичихэд хүрэх бөгөөд бичгийн харилцааны ажилд ихээхэн саад бэрхшээл тохиолдох болно. Үүнд ялангуяа нэгэн зүйлийн ухагдахууныг газар газар өөр өөрөөр нэрлэх буюу ерөнхийдөө нэгэн янзаар яривч чухам хэрэг дээрээ яг адилгүй хэлдэг энэ бүхэн нь улам ч төвөгтэй болгоно. Иймээс үсгийн дүрэм үнэхээр практик ач холбогдолтой нь хэн бүхэнд илэрхий.

Үг яриаг аман яриа, бичгийн яриа гэж хоёр зүйл болгон хуваадаг. Бичгийн яриа нь хүмүүсийн санал бодлоо солилцох нийгмийн нилээд тохиромжтой хэрэглүүрийн хувьд үлэмж өргөн хэрэглэгдэнэ. Хүн төрөлхтний түүхэнд бичиг үсэг бий болсон нь соёлын хөгжлийн явцад гарсан онцгой ач холбогдолтой түүхэн явдал мөн. Бичиг үсэг бол нийгмийн харилцааны нэгэн хэрэглүүр юм. Бичиг үсгийн ачаар хүн төрөлхтөн машэртний зүйлийг мэдэх боломжтой болжээ.

Бодол санаагаа бичгээр дамжуулах гэсэн хүсэл мөрөөдөл хүн төрөлхтний хөгжлийн үлэмж дээр цагт бий болсон билээ. Энэ эрмэлзлэлийн үр дүн болсон хамгийн эртний бичиг бол зураг бичиг юм. Зураг бичиг юмыг дүрсчлэн зурж хүний бодол санааг илэрхийлнэ. Жишээ нь: Энэ бичгээр, „Би анд явлаа“ гэсэн санааг дамжуулах гэвэл, хүн, ой, ан амьтан зурна. Ер нь өөрөөр хэлбэл, өгүүлэгч хүн дамжуулах гэж байгаа санаагаа уг бодит зүйлээр зурж илэрхийлдэг байжээ. Бичгийн анхны хэлбэр болох зураг бичгийн үндсэн дээр утга бичиг үүсчээ.

Зураг, утга, авианы бичиг эдгээр нь бичиг үсгийн хөгжлийн үе шатуудыг үзүүлнэ. Утга буюу дүрс бичиг Хятад, Япон, Египет зэрэг орнуудад үлэмжхэн дэлгэрчээ.

Хятадын эртний бичиг, зураг бичиг байсан нь эдүгээ утга бичиг болсон юм. Эртний Египетийн бичиг ч зураг бичиг, утга бичгийн аль алинд хамаарагдана.

Гэвч үсэг, үеэр бичих явдал Египетэд байжээ. Утга бичиг үлэмж олон дүрстэй. Жишээ нь: Эрдэмтэн А. Томсон<sup>1</sup> хятадын утга бичгийг 40000 дүрсээс бүтдэг гэж бичсэн байдаг.

Египетийн утга бичигт харах гэсэн үгийг хүний нүд зурж, өдөр гэсэн үгийг нарны хэлбэртэй дугуй юм зурж, явах гэсэн үгийг хүний хөл зурж, ээж гэсэн үгийг том шувуу зурж, хүү гэсэн үгийг дэгдээхэй зурах зэргээр тухайн санааг илэрхийлдэг байжээ. Энгийн бөгөөд хялбархан бичигтэй болох гэсэн эрмэлзлэл олон мянган жилийн турш хүн төрөлхтний оюун санаанд оршсоор иржээ.

Бичгийн хөгжлийн нилээд хожмын үед бий болсон, үлэмж боловсронгуй хэлбэр нь авианы бичиг юм. Энэ бичиг үет, үсэгт гэж хоёр янз байдаг. Барагцаалбал, манай эрэний өмнөх 1000-600 жилийн үед утга бичгийн үндсэн дээр үүссэн Ассир-Вавилоны шаантаг бичиг аажмаар үет бичиг болон хөгжжээ. Энэ бичгээр үгийг үе үеэр нь саланги бичдэг ажээ. Авианы бичиг анх манай үеийн өмнөх 10 дугаар зууны үед Финикт үүссэн билээ. Түүнээс хойш 3000-аад жил болжээ. Ийнхүү авианы бичиг бий болсон нь хүн төрөлхтний хөгжлийн нийт дэвшилтэнд зураг, утга бичгүүдээс илүү сайн нөлөө үзүүлсэн нь мэдээж хэрэг. Учир нь авианы бичиг урьдахь бичгийн зүйлүүдээс олон талаар давуу юм. Бичиг үсэг улам боловсорч сайжрахын хамт үсгийн дүрэм ч нэгэн адил боловсрон сайжирсаар иржээ.

Авианы бичигт, аман яриа, үсгийн дүрэм хоёр-

<sup>1</sup> А. Томсон. Общее языковедение. Одесса. 1906. (398-р тал)

ыг зохицуулах буюу өөрөөр хэлбэл, үсгийн дүрмийг зохион боловсруулахдаа авианзүй, үгзүйн, зарчмыг гол болгодог байна.

Ер нь үсгийн дүрмийг боловсруулахад авианзүй, үгзүй, уламжлалын буюу түүхийн ийм гурван үндсэн зарчмыг гол төлөв хэрэглэдэг билээ. Гэвч эдгээр зарчмын алиныг ч ямар ч гажуудуулалгүй мөрдөж болохгүй юм. Ийм учраас аль нэг зарчмыг гол болгоод бусдыг зохих ёсоор харгалздаг ажээ.

Үгийг тухайн үеийн хэлэх аялууг баримтлан бичих ёс байдаг. Үүнийг авианзүйн зарчим гэнэ.

Хааяа хэлэх аялгууг бага зэрэг гажуудуулавч үгийн утга бүхий хэсэг буюу үгийн язгуур, үндэс дагаварыг эвдэхгүйгээр бичих ёс бий. Үүнийг үгзүйн зарчим гэнэ. Хэлэх аялгуу, Үгийн үндэс зэргийг онц харгалзахгүй гагцхүү уламжлан ирсэн заншлыг баримтлан бичих ёс байдаг. Үүнийг уламжлалын буюу түүхийн зарчим гэдэг. Авианзүй, үгзүйн зарчим нь үсгийн дүрмийн норм хэмжээг тогтооход ихээхэн чухал зарчмууд юм. Аливаа бичгийн хэлний хөгжлийн бүр эхний үед авианзүйн зарчим нилээд зонхилохсуурьтай байх боловч, бичгийн хэл аажмдаа аман ярианы хөгжлөөс хоцорч тэдгээрийн хооронд зөрөө ялгаа зайлшгүй гарах тул ганцхан авианзүйн зарчмыг баримтлана гэхэд бэрхтэй болно.

Энэ нь манай классик бичгийн хэлний хөгжлийн түүхээс үзсэнч тодорхой байна. Ямар ч хэлний цагаан толгойн үсгүүд тэр хэлний авиалбар буюу фонемыг тэмдэглэхээс биш, бүх авианзүйн түүний бүх хувилбартай нь тэмдэглэдэггүй бөгөөд тэмдэглэх ч боломжгүй юм. Жишээ нь: Орос хэлний 41 фонемыг 32 үсгээр, Англи хэлний 44 фонемыг 26 үсгээр тэмдэглэсэн байдаг. Энэ мэтээр авианзүйн зарчим өөрийн байр суурийг үгзүйн зарчимд зайлшгүй тавьж өгнө.

Үсгийн дүрмийн зарчмууд өөр хоорондоо салшгүй холботой, тус тусдаа эзлэх байр суурьтай байдаг. Энэ нь тухай тухайн хэлний өвөрмөц байдлаас шалтгаалах хэрэг юм. Гэвч нилээд улс үндэстний үсгийн дүрэм үгзүйн буюу авиа-үгзүйн зарчмыг үн-

дэс болгож байна. Жишээ нь: Манай төрөл хэл болох буриад хэлний үсгийн дүрэм авианзүйн үгзүйн зарчим хоёрыг хоёуланг адил тэгш эрхтэй гол зарчим болгон хэрэглэж байна.<sup>1</sup>

Мөн эдүгээгийн оросын үсгийн дүрэм үгзүйн зарчмыг гол болгож байна. Гэвч оросын үсгийн дүрэм авианзүйн зарчмыг орхисон биш юм.

Басуламжлалын зарчмыг ч зохих ёсоор харгалзжээ. Оросын үсгийн дүрэмд тэмдэг үг, төлөөний үгийн эр, эрс хүйсийн ганц тоо, харьяалахын тийн ялгалын хэлбэрт « г » үсгийг одоо хүртэл уламжлалыг харгалзан бичиж байгаа үүнд: моего, белого, кого гэж бичээд моево, белово, ково гэж унших жишээтэй байна.

Үсгийн дүрмэнд үгзүйн зарчмыг баримталлаа ч гэсэн авианзүйн зарчмыг баримталсан бичлэгээс төдий л зөрдөггүй ажээ. Жишээ нь: профессор М. Н. Петерсоны бодож гаргаснаар орос хэлний үсгийн дүрмийн 63 % нь дуудлагатайгаа харшилдаггүй байна.

Үсгийн дүрмийн зарчмыг тогтоохдоо, юуны урьд тухайн хэлний өвөрмөц байдлыг онцлон анхаарч уг асуудлыг олон талаас нь нягтлан үзэх хэрэгтэй юм. Үсгийн дүрмийн ямар ч зарчмыг 100 хувь баримталж болдоггүй учраас тэдгээрийн аль нэгийг үндэс болгож, бусдыг зохих ёсоор харгалзах нь мэдээжийн хэрэг. Гэвч гагцхүү авианзүйн зарчмыг буюу уламжлалын зарчмыг үндэс болгоно гэхэд үнэхээр бэрхтэй. Учир нь нэгэн үе олны хэлэлцэх аялгуутай ерөнхийдөө тохирч байсан бичиг, аажимдаа амьд хэлнийхээ хөгжлөөс хоцроод сурахад үлэмж төвөгтэй болж ирнэ. Жишээ нь: 18-р зууны дундуур үеэс хойш одоо хүртэл өөрчлөгдөөгүй байгаа Английн үсгийн дүрэм эдүгээ англичуудын хэлэлцэх аялгуунаас асар их зөрөөтэй болжээ.

---

<sup>1</sup> Д. Амоголонов. „Современный бурятский язык „Улан-Үдэ. 1958. (57-р талд үз)

Английн үсгийн дүрэм анх зохиогдох үедээ олны хэлэлцэх аялгуунаас одоогийнх шиг зөв өөтэй байгаагүй нь мэдээжийн хэрэг. Харин яваандаа ярианы хэлнээс хэсрөөд Францын үсгийн дүрмийн адил уламжлалын зарчмыг хадгалсан дүрэм болжээ.

Монголын хуучин үсгийн дүрэм ч мөн иймэрхүү шинжтэй болж ирсэн билээ.

Английн үсгийн дүрэм ёсоор хоёр буюу хэд хэдэн үсгээр бичээд нэг авиагаар дуудах явдал өдий төдий тохиолдоно. Жишээ нь: Англичууд «Бодсон, санасан» гэсэн үгийг 7 үсгээр бичээд 3 авиагаар. «Эх» гэдэг үгийг 6 үсгээр бичээд 4 авиагаар. «Сургасан» гэдэг үгийг 6 үсгээр бичээд 3 авиагаар тус тус уншдаг байна. Энэ нь дээрхи хэлний дуудлага бичлэг хоёр ихээхэн зөрөөтэй болсныг харуулж байна.

Зөвлөлтийн эрдэмтэн М. Галинская, З. Цветкова нар<sup>1</sup> „Английн үсгийн дүрэм үлэмж хуучирсны улмаас эхэлж сурахад ихээхэн бэрхшээлтэй. Эдүгээгийн ангийн үсгийн дүрэм бараг таван үе болж байгаа бөгөөд дуудлага нь үлэмжхэн өөрчлөгдсөн боловч дүрэм нь одоо хүртэл бараг өөрчлөгдөөгүй“ гэж тэмдэглэжээ.

Манай классик бичгийн үсгийн дүрэм ч гэсэн урт хугацааны дотор онцын өөрчлөлтгүй хэрэглэгдэж ирсэн учраас ярианы хэлнээс ихээхэн холдсон юм. Түүний үндсэн зүйлүүд одоогоос 1000 орчим жилийн өмнө боловсорсон билээ. Гэвч жинхэнэ монгол үсгийн дүрэм энэ гээд үзүүлэх анхны дүрмийг манай алдарт эрдэмтэн Чойжи-Одсэр 14 р зууны үед зохиожээ.

Эрдэмтэн Чойжи-Одсэрийн зохиосон монголын анхны үсгийн дүрэм буюу хэлзүйн бичгийн жинхэнэ эх нь одоо хүртэл олдоогүй боловч түүний тоймыг мэдэж болох материал бидэнд үлдсэн нь тэмдэглэлтэй хэрэг юм. Эртний бичгийн хэлэнд үсгийн дүрмийн нормыг тогтоохдоо, их төлөв уг үсгийн дүрмийг

1 М. Галинская, З. Цветкова, „Учебник английского языка“. Москва. 1953. (10-р тал)

зохиох үед хэрэглэгдэж байсан бичлэгийн жуурыг аль болохоор бэхжүүлхийг эрмэлздэг байжээ. Энэ нь бичиг үсгийн хөгжлийн бүр эхний үед жинхэнэ бичиж тэмдэглэсэн дүрэм байгаагүй явдалтай холбоотой юм. Нэгдмэл бөгөөд тодорхой дүрэмтэй байх явдал бичгийн хөгжлийн явцад аяндаа шаардагджээ. Энэ шаардлагын үндсэн дээр үсгийн дүрэм бий болсон байна. Үсэг бичиг үүсч байх үед тусгайлан бичиж тэмдэглэсэн үсгийн дүрэм байгаагүй ч гэсэн ялангуяа авианы бичигт ямар нэг дүрмийн үүсэл зүйл эрхбиш байсан буй за. Харин зураг бичигт бол тухайн юуыг зөвхөн дүрсээр нь зурж санаагаа илэрхийлдэг болохоор үсгийн дүрэм шаардагдахгүй юм. Энэ нь мөн угтаа бичигт ч ихээхэн холбогдолтой билээ. Үсгийн дүрмийн үүсэл нь угтаа үсэгт бичиг бий болсон явдалтай салшгүй холбоотой. Үсгийн дүрэм илүү, зөрүү зүйлгүй нэгдмэл байх нь их чухал.

Нэг үгийг хоёр буюу хэд хэдэн янзаар бичвэл унших бичихийн аль алинд бэрхшээлтэй болохсор барахгүй, хэвлэл хянагч, найруулан засагч нарт ч муугаар нөлөөлнө. Ийм учраас боловсон, сайн үсгийн дүрэм зайлшгүй хэрэгтэй бөгөөд түүнийг боловсруулахад зарчмын асуудал асар их ач холбогдолтой юм. Оросын их эрдэмтэн М. В. Ломоносов, үсгийн дүрмийн зарчмын асуудалд ихээхэн анхаарал тавьж байсан бөгөөд үгзүйн зарчмыг баримталсан үсгийн дүрэм хэрэгтэй гэж үзэж байжээ. Бүтээвэр буюу морфемуудаас бүтсэн хэлэнд үгзүйн зарчмыг баримталсан бичигтэй байх боломжтой юм. Харин тиймгүй, үг бүр нь задашгүй хэсгээс бүтсэн хэлэнд үгзүйн зарчмыг хэрэглэх аргагүй.

Манай монгол хэл бол морфемуудаас бүтсэн хэл болохоор үсгийнхээ дүрэмд үгзүйн зарчмыг голлон баримтлах бүрэн боломжтой. Ийм ч учраас 1957 оны 7-р сард Улаанбаатар хотноо хуралдсан Монгол, Зөвлөлт, Хятад гурван улсын хэл бичгийн эрдэмтэн нарын „Монголын шинэ үсгийн дүрмийн асуудал хэлэлцэх“ эрдэм шинжилгээний зөвлөлгөөний анхаарлын төвд зарчмын асуудал байсан юм.

Тэгээд ч тэр зөвлөлгөөнөөс „Үсгийн дүрмийг

цаашид боловсруулахдаа үгзүй, аианзүйн зарчмыг хослон хэрэглэж, түүхэн зарчмыг харгалзах, үгийн үндэс дагаврыг аль болохоор тогтвортой болгох нь чухал" гэж заасан билээ.

Үгзүйн зарчим дээр үндэслэгдсэн зөв бичих дүрмийг эзэмшихэд дор дурдсан зүйл зайлшгүй шаардагдана. Үүнд:

1. Үгийг бүрэлдэхүүнээр нь задалж болдог байх, өөрөөр хэлбэл үгийг утга бүхий хэсгүүдээр нь зөв заагласан байх.

2. Хэлний авианы тогтолцоо, түүний зүй тогтоолыг мэдэх эдгээр болно. Үүнийг анхаарч үзэхгүйгээр үсгийн дүрмийн зарчмын асуудлыг зөв шийдвэрлэж чадахгүй нь мэдээж юм.

Монголын классик бичгийн дүрэм, олон улсын үсгийн дүрмийн чухал зарчим болсон үгзүйн зарчмыг гол болгосон юм.

Энэ тухай профессор Б. Ринчений бичсэн нь: „ Монгол хэл бичгийг шинжлэн үзсэн монголч эрдэмтэн цөм, манай монгол үсгийн дүрмийг „ Үгийн зүй“ баримталсан зарчимтай юм гэж шинжилсэн үүнд, тэр „ Үгийн зүйн зарчим“ нь юу юм бэ? гэвэл, монгол хэлний үг бүтээгч зүйл, тухайлбал, үгийн язгуур угсран залгах дагаврыг хэрхэн бичих дүрмийг нэгэн мөр болгодог зарчмыг хэлдэг юу юм. Жишээ нь: хуучин монгол бичигт гал гэдэг язгуур үг огт үл хуви-лан гал-ла, гал-ла-н, гал-ла-жу, гал-ла-нам, гал-ла-гад, гал-ла-муй гэх зэргээр гал гэдэг язгуур үгнээ ла, н, жу, нам, гад, муй гэх зэрэг үг бүтээгч язгуур дагаврын зүйлийг бичих дүрмийг нэгэн мөр болгожээ.

Энэ зарчим бол хамаагүй, хайш хэрэг бичдэг ёс биш, манай хэлний зүйн тогтоолыг үзүүлсэн дүрэм байжээ. Тэр дүрмийн ёс зүйн гол төлөв нь мянгаад жилийн өмнө тогтож тэр үеийн монгол хэлний авианы тогтолцоог нилээд нарийн үзүүлж байсан учраас нутаг нутгийн аялгуунд дуудлага өөр өөр байгаа зүйл үзэгдсээр ирсэн байвч үг бүтээх ёс зүй нь монгол хэлэнд Монголын олон нутгийн олон аман аялгуунд зарчим нэгтэй байсан учраас тэр гол зарч-

мыг баримталсан үсгийн дүрэм хэлнийхээ хэрэгцээг хангасаар иржээ”<sup>1</sup> гэжээ.

Олон үеийн турш хэрэглэсэн манай классик бичгийн үсгийн дүрмийн зарчмын ерөнхий төлөв нь ийм байна.

Бидний одоогийн хэрэглэж байгаа үсгийн дүрэм үгзүйн зарчмыг зохих ёсор баримтлаагүй буюу авиан зүйн, үгзүйн зарчим хоёрыг зөв хослуулж чадаагүй учраас бараг үсэг нэг бүрийг бичих тус тус дүрэм зохиоход хүрчээ. Тэгээд юу болсв гэвэл? эгшигт 7, заримдаг 9 ийн дүрэм, хатуу, зөөлний тэмдгийн дүрм, шилжих, гээгдэх эгшгийн дүрэм гэх мэтийн өдий төдий олон илүүц дүрэм бий болсон бөгөөд тэр нь үсгийн дүрмийг улам төвөгтэй болгосон юм. Үүнтэй холбогдуулан нэгэн жишээг үгүүлбэл: дээр дурдсан Монголын шинэ үсгийн дүрмийн асуудал хэлэлцэх Монгол, Зөвлөлт, Хятад гурван улсын хэл бичгийн эрдэмтэн нарын эрдэм шинжилгээний зөвлөлгөөн дээр, зөвхөн я, ё, е, ю, ы, и, й, ь, ь, к, ф, щ, б, в, н, г зэрэг 16 үсгийг зөв хэрэглэж эзэмшхийн тул 134 томъёоллыг чээжлэх хэрэгтэй болдог юм гэж зарим хүн баримт дурдан ярьж байсан билээ. Энэ бол бид үсгийнхээ дүрмийг анх зохиоходоо, түүний зарчмын асуудлыг нарийн чанд боловсруулаагүйгээс шалтгаалсан хэрэг бөгөөд үүний улмаас нэг үгийг хэд хэдэн янзаар бичих, тэдгээрийн чухам аль нь зөв, аль нь буруу болохыг дүрмээр шийдвэрлэж чадахгүйд хүрэх, үгийн үндэс, дагавар эвдрэх, нэг зүйлийн дагавар олон хувилбартай болох зэрэг эмх журамгүй явдал гарах боломжтой болжээ. Жишээ нь: Хоёулан, хоюулан, төгсч, төгсөж, урсч, урсаж, эрчилбэл, эрчлэвэл, эрчлэмээр, эрчилмээр, судалбал, судлавал, судалмаар, судламаар гэхэд чухам алий нь зөв гэх вэ? Суртал, сур-тл-ын, сур-тл-аар, үзэл, үз-л-ийн, үз-л-ээр, нутаг, нутг-ийн, нутг-аар гэх зэрэг өдий төдий үгийг бичихэд үгийн үндэс эвдэрч байна. Бас лга, лгэ гэсэн хоёр зүйлийн дага-

<sup>1</sup> Б. Ринчен . „Бичиг үсгээ боловсон болгох хэрэгтэй“ үгүүлэл. 1957 он.

вар лга, лго, лэг, лог, лага, лого, лгээ, лгоо, лгөө, лгаа, гэсэн 10 хувилбартай болжээ. Энэ мэтийн жишээ олныг дурдаж болно.

Аль ч улс гүрэнд ярьдагаараа бичдэг буюу дан авианзүйн зарчмыг баримталсан бичиг нэг ч үгүй бөгөөд байж ч болохгүй юмга. Учир нь ямарваа хэлэнд авиалбар буюу фонемоос гадна фонемын хувилбар олон авиа байдаг. Жишээ нь: Орчин цагийн монгол хэлний, а "авиа 5 хувилбартай," ө "авиа 4 хувилбартай байна. Хэрэв хэлдэгээрээ бичнэ гэвэл эдгээр авиаг цөмийг бичих хэрэгтэй болно.

Эд бүгдийг гагцхүү галиг үсэгт тэмдэглэхээс биш ерийн бичигт тэмдэглэж болохгүй нь мэдээж юм.

Хэлний зүйн бичиг хэлэндээ дүрмийг өгдөг биш харин хэлнээсээ дүрмийг гаргаж авдаг юм гэж Оросын их сэтгэгч В. Г. Белинскийн хэлснийг санахад илүүдэхгүй. Энэ бол үсгийн дүрэм тухайн хэлний зүй тогтоолыг түшиглэх хэрэгтэй гэсэн үг бөгөөд харин ярианы хэлийг яг баримтал гэсэн үг биш билээ.

Гэтэл манай зарим нөхөд ярьдагаараа бичихэд яг тохирсон дүрэмтэй байж болох юм шиг ярьдаг. Тэгээд тэд шинэ үсгийн дүрэмд авианзүйн зарчмыг баримтлах хэрэгтэй гэж зүтгэдэг. Хэлдэгээрээ бичнэ гэдэг хүмүүс хамгийн наад зах нь улс үндэстний ерийн бичиг, эрдэм шинжилгээний ажилд хэрэглэдэг галиг үсэг хоёрын ялгааг үзтэл үгүйсгэж байна. Үүгээрээ тэд үсгийн дүрмийн зарчмын асуудлыг бүрхэгдүүлж, ард нийтийн сурч боловсроход үлэмж төвөгтэйгээр барахгүй, эх хэлнийхээ зүйн тогтоолыг таниж мэдэхэд саад бэрхшээл болж болох тийм өрөөсгөл дүрмийг бий болгоход хүргэж байна.

„Ямар ч үсгийн дүрэм аман яриаг яг тэр хэвээр нь тэмдэглэдэггүй юм“ гэж профессор Ж. Вандриесийн хэлснийг дээрхи нөхөд санууштай.

Үсгийн дүрмийн асуудлыг шийдвэрлэхэд авиан-

---

<sup>1</sup> Ж. Вандриес „Язык“ 1937. Москва. (300 дугаар тал)

зүй, үгзүй, түүхийн ийм гурван үндэс зарчмыг дэвшүүлэн тавьдгийг дээр өгүүлсэн. Эдгээр нь үсгийн дүрмийн ерөнхий зарчмууд болох бөгөөд өөр зүйлийн зарчим байхыг үгүйсгэсэн хэрэг бишээ.

Зарим эрдэмтэн<sup>1</sup> үсгийн дүрмийн зарчмыг авианзүйн зарчим, фонемын зарчим, үгзүйн зарчим бэлэг тэмдгийн зарчим, түүхэн зарчим, гаралзүйн зарчим гэх зэргээр зургаан зүйл болгож хуваасан байдаг. Авианзүй, үгзүй, түүхэн зарчмын тухай дээр өгүүлсэн болохоор энд давхардуулах хэрэг юун ажээ.

Үсгийн дүрмийн фонемын зарчим гэдэг бол урьд хойтох авианаас шалтгаалан хувирах фонемын хувилбарыг анхаарахгүй, зөвхөн фонемыг тэмдэглэх, өөрөөр хэлбэл фонемын хувилбаруудыг нэг тэмдгээр тэмдэглэхийг хэлнэ. Жишээ нь: б авиа орчин цагийн монгол хэлэнд хэдийгээр б хувилбартай байгаа боловч түүнийг зөвхөн « б , в » хоёр дүрсээр тэмдэглэж байна. Бэлэг тэмдгийн зарчим гэж адил дуудлагатай үгийг өөр өөрөөр бичих ёсыг хэлнэ. Ийм зарчим манай классик бичгийн дүрмэнд бий. Жишээ нь: уул, хад, гэдгийн хад, хадах, чавчих гэдгийн хад хоёрыг хада, хаду, тэнгэрийн сар, сар жилийн сар хоёрыг саран, сар-агэх зэргээр ижил дуудлагатай үсгийг өөр өөрөөр бичдэг билээ.

Гаралзүйн зарчим гэдэг нь хэлний өнгөрсөн үеийн байдлыг тусган бичихийг хэлнэ. Үсгийн дүрмийг боловсруулахад энэ мэтийн олон янзын зарчим хэрэглэж болдгийг эрдэмтэн нар тус тус тэмдэглэсэн байдаг. Жишээ нь: Буриадын эрдэмтэн Д. Амоголонов<sup>2</sup> „Орчин цагийн буриад хэл“ гэдэг номондоо, „Аман яриаг үсгийн дүрмийн дөрвөн зарчмын үндсэн дээр бичигт оруулж болно. Үүнд утгын зарчим,

---

<sup>1</sup> А. А. Реформатский. Введение в языкознание Москва. 1955. (291-294-р тал)

<sup>2</sup> Д. Д. Амоголонов „Современный бурятский язык“. Улан-Үдэ. 1958. (57-р тал)

авианзүйн зарчим, үгзүйн зарчим, түүхийн зарчим эдгээр болно" гэжээ.

Авианы бичгийн үндсэн зарчим нь үг яриаг бичигт оруулах явдлыг аль болохоор тогтвортой болгож чадахуйц бөгөөд хэлний ямар нэгэн нэгжээр тодорхойлогдсон байх ёстой.

Тийм нэгж гэвэл:

1. Авиа буюу холбоо авиа (үе).
2. Бүтээвэр буюу (үгийн язгуур, үндэс, дагавар) өөрөөр хэлбэл үгийн утга бүхий хэсэг.
3. үг эдгээр болно.

Үгзүйн зарчим нь авианзүйн зарчимтай ямагт зөр-

дөг биш, харин түүнийг мэдээж хэмжээгээр түшиглэдэг байна. Үгзүйн зарчмын үндэс нь бүтээвэр, авианзүйн зарчмын үндэс нь авиа юм. Уламжлалын бичлэг нь уг чанартаа үгзүйн бичлэг юм. Учир нь уламжлалын бичлэг хувирахгүй нэг л янзаар бичигдэж байдаг.

Авианзүйн зарчим авиа буюу холбоо авиаг гол болгодог учраас түүний биеэ дааж тэмдэглэх хэлний нэгж нь авиа буюу холбоо авиа болно. Харин үгзүйн зарчмыг баримталсан бичигт биеэ дааж тэмдэглэх хэлний нэгж нь бүтээвэр буюу үгийн утга бүхий хэсэг байдаг. Ийм бичигт нэг зүйлийн бүтээвэр ямар ч үед (дуудлагат хамаарахгүйгээр) нэгэн янзаар бичигдэнэ. Энэ бол үгзүйн зарчмын онцлог юм. Харин түүхийн зарчим нь уламжлалын бичлэгийг хамгаалдаг байна. Орост 1917 оны үсгийн дүрмийн шинэчлэлтийг хүртэл уламжлалын зарчмыг харгалзан, огт шаардлагагүй газар хатуугийн тэмдэг хэрэглэж столъ, домъ, полъ гэх зэргээр бичиж байжээ. Энэ мэт илүү, хэрэггүй зүйлийг бичих нь ашиггүйгээр барахгүй, харин зарим талаар хортой юм.

Тийм ч учраас оросын үсгийн дүрмийн дээр дурдсан өөрчлөлтөөр тийнхүү хэрэгцээгүй газар хатуугийн тэмдэг бичдэг явдлыг зогсоожээ. Үсгийн дүрэм хэдийчинээ нэгдмэл, зарчимтай, уг хэлнийхээ онцлог байдлыг зөв сайн тусгасан байвал олон ний-